

- 8** 1 - 4 тоо бүхий ээрүүл эргүүдэхийн зэрэгцээ шоо орших туршилт хийжээ. Энэ туршилтын үр дүнд дэс дараалсан хоёр үзэгдлээс тогтох нийлмэл үзэгдэл илрэнэ.
- Бүх боломжит эгэл үзэгдлийг хүснэгтээр харуулаарай. Эгэл үзэгдлүүдийн магадлал тэнцүү юу?
 - Ээрүүл тэгш тоогоор тогтох, шоо сондгой тоогоор тусах үзэгдэл хэдэн эгэл үзэгдлээс тогтох вэ? Уг үзэгдлийн магадлалыг ол.
 - Ээрүүл ба шооны тооны нийлбэр 8-тай тэнцэх үзэгдэл хэдэн эгэл үзэгдлээс тогтох вэ? Магадлалыг олоорой.
 - Магадлал нь $\frac{1}{12}$ -тэй тэнцүү ямар нэгэн үзэгдлийг ол.
- 9** Зоосон мөнгийг 3 удаа орших туршилт хийв.
- Туршилтын дүнд нийт хэчинээн эгэл үзэгдэл илрэх вэ? Эгэл үзэгдлүүдийн магадлал тэнцүү байж чадах уу?
 - Бүх боломжит эгэл үзэгдлийн магадлалын нийлбэр 1-тэй тэнцүү болохыг шалгаж учрыг нь тайлбарлаарай.
 - Зоосон мөнгө аль талаараа тусах нь өмнөх орхилтын үр дүнгээс хамааралтай юу? Гурван удаа сүлд буух үзэгдлийн магадлал ямар байх вэ?
- 10** Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй.
 Дэс дараалсан үл хамаарах хоёр буюу хэд хэдэн үзэгдлээс тогтох үзэгдлийн магадлалыг олохын тулд тухайн үзэгдлүүдийн магадлалыг
 Хоёр буюу хэд хэдэн нийшгүй үзэгдлийн ядаж нэг нь илрэх магадлалыг олохын тулд тухайн үзэгдлүүдийн магадлалыг
- 11** Уутанд 10 улаан, 20 ногоон өнгийн чихэр байв. Уутанд гараа оруулан тэмгэрч чихэр гаргаж ирэхэд ногоон өнгөтэй байв. Дахин нэг чихэр гаргаж ирэхэд улаан өнгөтэй байх магадлалыг ол.
- 12** Батын цүхэнд 4 улаан, 4 ногоон харандаа байв. Тэрээр цүхнээсээ таамгаар нэг харандаа гаргаж ирэхэд тэр нь ногоон өнгийнх байв. Дахин нэг харандаа гаргаж ирэхэд бас ногоон байх магадлалыг оло.